

Бат-Өлзий сумын Засаг даргын зөвлөлийн
2023 оны..... дугаар сарын-ний
өдрийн хуралдаанаар батлав.

БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2023 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2023.12.08

Өвт

№	Дунд хугацааны бодлогын баримт бичиг	Арга хэмжээ	Хүрэх үр дүн	Шалгуур үзүүлэлт	Шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр	Биелэлт	Хувь
1	2	3	4	5	6	7	8
Нэг. Эдийн засгийн хөгжлийн бодлого							
1.1	СЗДҮАХ	Малын гаралтай түүхий эдэд түшиглэж, ноос ноолуур, арьс, шир боловсруулах, элдэх, хүнсний ногоо боловсруулах цех байгуулах.	Ажлын гүйцэтгэлээр	Арьс шир элдэх, хүнсний ногоо боловсруулах цехтэй болсон байна.	ХХСан	2023 оны 6-р сард 2-р багийн Засаг дарга Share Mongolia ХХК-тай хамтран багийнхаа 25 иргэнд цахилгаан багажаар 5 хоногийн хонь хяргах сургалтыг зохион байгуулсан. Сургалтаар 2350 толгой хонийг хярган өнгөөр болон үргэлж хэвийн, бутархай 2,6 тн ноосыг ангилж сумын “Дэлгэр баян ундрах” хоршоонд тушаасан. Малчдын хамтын хүч хоршоо 2.5 сая төгрөгөөр сарлагийн хөөвөр самнах хашаа хийж 5 өрхийн 78 сарлагийг самнаж туршсан. Тус хоршоо 41 малчнаас 700 кг сарлагийн хөөврийг 20,0 төгрөгөөр, 167 малчнаас 3,8 тн ноолуурыг авч Үлэмж кашмер ХХК нийлүүлсэн. Борлуулалтын ашгийн зөрүүнээс 1 кг ноолуурт 1000-1500 төгрөгийн урамшуулал олгосон. Тус хоршоо өөрийн хөрөнгөөр нэхий элдэх иж бүрэн төхөөрөмж худалдан авч	70

						<p>суурилуулан 4-р багийн иргэн Д.Дэлгэржаргалыг Улаанбаатар хотод 14 хоногийн сургалтад хамруулсан. Улаанбаатар хотоос нэхийний технологичийг 10 хоногийн хугацаатай урьж авчран дадлага сургалтыг хийлгэн цех өдөрт 40-50 ширхэг нэхий элдэх хүчин чадалтай цехтэй болсон.</p> <p>Иргэн Э.Мөнхсайхан, Ж.Мөнхтогтох, Э.Эрдэнэбат, Ч.Довчин, Д.Гандөш нар гар аргаар болон зориулалтын төхөөрөмжөөр нэхий элдэж өрхийн орлогоо нэмэгдүүлэн ажиллаж байна.</p> <p>Иргэн Ч.Мягмарсүрэн, Р.Нансалмаа нар алаг салат, лууван, хүрэн манжингийн салат, газрын алим, хулуу луувангаар варень, улаан лоолиор кетчуп гэх мэт бүтээгдэхүүнийг хийж ард иргэдээ эко, шинэ хүнсээр хангадаг. Цаашдаа эдгээр иргэд өрхийн үйлдвэрлэлээ өргөжүүлэн цех болон хөгжих бололцоотой.</p>	
1.2	СЗДҮАХ 1.3.2	Жижиг дунд үйлдвэрлэлийг хөнгөлөлттэй бодлогоор хэвшүүлэх зээлийн дэмжиж	Ажлын гүйцэтгэлээр	Иргэдийн ажилтай, орлоготой болоход дэмжлэг болно.	ЖДҮ, ХХСан	<p>Хоршоо хөгжүүлэх сангаас: нийт 2 хоршоо, 44 иргэнд 414 сая төгрөгийн зээлийг олгосон. Үүнд: 2020 онд 22 иргэнд 118 сая, 2021 онд 13 иргэнд 49 сая, 2022 онд 1 хоршоо, 2 иргэнд 138 сая, 2023 онд 1 хоршоо 7 иргэнд 109 сая төгрөгийн зээлийг тус тус олгосон.</p> <p>Жижиг дунд үйлдвэрлэлийн сангаас: Нийт 2 аж ахуй нэгж 324 сая төгрөгийн зээл олгосон. Үүнд: 2020 онд “Арвинлхам очир” ХХК нь модон сав хийх чиглэлээр 45 сая төгрөг, 2023 онд “Их Сумт хайрхан” ХХК мод үржүүлгийн чиглэлээр 279 сая төгрөг тус тус олгосон.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын хүүгийн хөнгөлөлттэй зээлээс: Банкаар дамжуулан нийт 222 иргэнд 3,7 тэрбум төгрөгийн зээл олгосон: Үүнд: 2021 онд 103 малчинд малын тоо толгойг өсгөх,</p>	100

						малын үүлдэр угсааг сайжруулахад 643.2 сая төгрөг, 117 бизнес эрхлэгч иргэнд эргэлтийн хөрөнгө нэмэгдүүлэх чиглэлээр 3.1 тэрбум төгрөгийн зээл олгосон. 2023 онд газар тариалангийн үйлдвэр эрхлэгч 2 иргэнд 46 сая төгрөгийн зээл олгосон.	
1.3	СЗДҮАХ 1.1.3	Сумын онцлог, өв уламжлалыг харуулсан бэлэг дурсгал, гар урлал, үндэсний дээл хувцас, гоёл чимэглэл, уран хатгамал зэрэг брэндэд чиглэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, сав баглаа боодлын үйлдвэрлэлийг дэмжих ажлын байр бэлтгэх.	Ажлын гүйцэтгэлээр	15 иргэнийг шинээр ажлын байртай болгоно /4 жилээр/	ЖДҮ, ХХСан	Брэнд бүтээгдэхүүнтэй болох, үйл ажиллагааг өргөтгөх зорилгоор хоршоо хөгжүүлэх сангаас 2020 онд оёдлын чиглэлээр 2 иргэнд 8,0 сая төгрөг, ширмэл ширдэг ширэх чиглэлээр 1 иргэнд 4,0 сая төгрөг олгон 1 ажлын байр шинээр нэмэгдэж, 2 ажлын байр хадгалсан. 2021 онд "Жаргалхүү ХХК"-ийн Хатан зөгий үржүүлэх төсөлд 5 сая төгрөг, иргэн Ч.Цэрэндолгорын "Монгол дээл, монгол хувцас"-ны төсөлд 3 сая төгрөг, иргэн С.Даваанямын "Үндэсний урлан" монгол гутлын төсөлд 5 сая төгрөг олгон 4 ажлын байр хадгалсан. 2022 онд "Жаргалхүү ХХК"-ийн Зөгийн бүл нэмэх төсөлд 15,0 сая төгрөг олгон 2 ажлын байр хадгалсан. 2023 онд С.Давааням "Үндэсний урлан" монгол гутлын төсөлд 5,0 сая төгрөг, иргэн Ш.Чанцалням оёдлын чиглэлээр 5,0 сая төгрөг олгон 3 ажлын байр шинээр нэмэгдэж, 2 ажлын байр хадгалсан. Хөдөлмөр халамж үйлчилгээний газраас иргэн Ч.Ганбаатарт арьс ширээр бүтээгдэхүүн хийх төсөлд 5,0 төгрөгийн зээл олгож 1 ажлын байр нэмэгдсэн. 2023 онд Иргэн А.Цэвэлмаа шар сүүн чихэр, М.Авиржаргал цайны эзэгий, Ж.Дагиймаа талх нарийн боов үйлдвэрлэж сав баглаа боодлыг оновчтой шинэлэг хэлбэрээр шийдэж 3 ажлын байр шинээр нэмэгдүүлсэн. Шинээр 8 ажлын байр нэмэгдэж, 10 ажлын байрыг хадгалан ажиллаж байна.	100

						2021 онд Японы хүүхдийг ивээх сангаас орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар энтерпрэнершип боловсрол олгох төсөлд ЕБС-ийн 6 баг шалгарснаас 2 төсөл нь гар урлал буюу малгай ороолт, бээлий, утас болон хүзүүний зүүлт хийх, гайд клуб буюу сумын байгалийн үзэсгэлэнт газруудаар түлхүүрийн оосор, хөргөгчийн наалт, бал хийн буцалтгүй 2,8 сая төгрөгийн санхүүжилт аван бүтээгдэхүүнээ хийн борлуулж байна.	
1.4	СЗДҮАХ 1.1.5	Байгалийн нөөцийг зохистой ашиглах, жимс жимсгэнэ, малын тэжээл тариалах чиглэлээр 50 га хүртэл талбайг эзэмшүүлж эргэлтэд оруулна.	Ажлын гүйцэтгэлээр	50 га-д малын тэжээл, жимс жимсгэнэ тариулсан байна		Билүүт, Онгоцот, Баруун сөдтийн атаршсан 200 га талбайг эргэлтэд оруулахаар хэмжилт хийн эзэнжүүлэн олгосон. Үүнээс 53 га талбайд малын тэжээл тарьж өвс, тэжээлийн нөөц бүрдүүлсэн. Чацаргана 1.4 га газраар нэмэгдүүлэн 1150 суулгац шинээр тарьсан.	100
Хоёр. ХОТ БАЙГУУЛАЛТ, ДЭД БҮТЭЦ							
2.1		Бугатын амны зам засна.	Ажлын гүйцэтгэлээр	Иргэдийн аюулгүй зорчих орчин бүрдэнэ	ОНХС 20,0 сая	Бүрэгтий багийн Бугатын амны хэжүүгийн замыг “Хансэнтэй” ХХК 18,8 сая төгрөгөөр засварласан. Гүйцэтгэл 70 хувьтай	90
2.2		Хөнөгийн голын гүүр засна.	Ажлын гүйцэтгэлээр	Иргэдийн аюулгүй зорчих орчин бүрдэнэ	ОНХС 20,0 сая	Улаан-Ам багийн Хөнөгийн голын гүүрийг “Хансэнтэй” ХХК 19,0 сая төгрөгөөр засварлаж байна. Гүйцэтгэл 30 хувь	30
2.3		Зөрүүлэг багийн төвийн урд голд гүүр тавина.	Гүүртэй болсон байна.	Иргэдийн ая тухтай зорчих нөхцөл бүрдэнэ	ОНХС 120,0 сая	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Зөрүүлэг багийн төвийн урд голд төмөр бетон гүүрийг “Мотор сервис” ХХК 2023 онд 120,0 сая төгрөгөөр барьж ашиглалтад хүлээлгэн өгсөн.	100
2.4	СЗДҮАХ 1.2.2	Хужирт-Бат-Өлзий чиглэлийн авто замыг шинээр барих зураг төсвийг хийлгэж барьж эхлэх.	90%-д хүргэнэ	Аялал жуулчлал хөгжиж иргэдийн амьжиргааны түвшин сайжирна.	Улсын төсөв	Хужирт-Бат-Өлзий чиглэлийн авто замыг шинээр барих ажил 50 хувьтай явагдаж байна.	50

2.5	СЗДҮАХ 1.2.3	Наймаа булан, Өвт, Бэл хорооллын үерийн далан барих.	Ажлын гүйцэтгэлээр (15-20%)	Иргэдийн ая тухтай амьдрах орчин сайжирна	ОНХС 162,2 сая	Наймаа булан, Өвт, Бэл хорооллын үерийн далан барих ажлын зураг төсвийг 2022 онд 20,0 сая төгрөгөөр боловсруулсан. Үерийн далан эхлүүлэх ажлыг ОНХС-н хөрөнгө оруулалтаар хийхээр 2023 оны төсөвт 162,2 сая төгрөг батлуулсан. Тус ажлын тендерийг 2 удаа зарласан. Эхний удаа ААНБ оролцоогүй, дараагийн зарласан тендерт “Тулгат зам” ХХК шалгаран гүйцэтгэж байна. Ажлын гүйцэтгэл 50 хувь.	100
2.6	СЗДҮАХ 1.2.4	Цаг уур, Наймаа булангийн 6 дугаар гудамжнаас хойш, Өвтийн 17 дугаар гудамжнаас хойш, Бэлийн 11 дүгээр гудамжнаас хойш өргөн чөлөөнд гэрэлтүүлэг тавих. (Жогом, ЕБС-ийн арын гэрэлтүүлэг засвар)	Нийтийн эзэмшлийн төв зам дагуу гэрэлтүүлгийн тоо хэмжээг нэмэгдүүлсэн байна.	Иргэдийн аюулгүй амьдрах орчин бүрдэнэ	ОНХС 69,0 сая	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2023 онд Наймаа буланд-4, дунд өргөн чөлөөнд-9, доод өргөн чөлөөнд-8, цехийн урд зам дагуух гэрэлтүүлэг гүйцээхээр- 3, 1-р Цэцэрлэгийн ард-2, Сургуулийн арын зам дагуу-7, Ерөнхий боловсролын сургуулийн баруун талын гэрэлтүүлэг гүйцээхээр-4, 16 ширхэг нэг тусгалтай, 21 ширхэг 2 тусгалтай нийт 37 гэрэлтүүлгийг бүрэн хийж гүйцэтгэсэн.	100
2.7	СЗДҮАХ 1.2.5	Бүрэгтий багийн төвийг өндөр хүчдэлд холбох, суурьшлын бүс болгох.	Ажлын гүйцэтгэлээр	Өндөр хүчдэлийн шугамд холбогдсон байна	ОНХС 50,0 сая	Бүрэгтий багийн төвийг өндөр хүчдэлд холбох, тог татах шугамын ажлын тендер 2 удаа зарлагдсан боловч нэг ч аж ахуйн нэгж ороогүй. ЭБЦТС, ОХБЦТХГ-аас тог татах зөвшөөрлийн авсан.	90
2.8	СЗДҮАХ 1.2.9	Сумын төвд цамхагт гэрэлтүүлэг 2-ыг барих.	Ажлын гүйцэтгэлээр	Сумын төвийн өнгө үзэмж сайжирна	ОНХС 11,0 сая	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2023 онд Цаг Уур, Рамын дэнжид -1, ЗДТГ-ын төв талбайд-1, Багийн төвийн баруун талд-1, Үржүүлэхэд-1, Жогом хорооллын замд-1, шинэ сургууль цэцэрлэгийн дунд-1 нийт 6 ширхэг 6 талтай Цамхагт гэрэлтүүлэг барьж ашиглалтад оруулсан.	100
2.9	СЗДҮАХ 1.2.11	Улаан-Ам багийн Улааны хэжүү, Амгалангийн хошууны замыг засварлах	Ажлын гүйцэтгэлээр	Иргэдийн аюулгүй зорчих орчин бүрдэнэ	Иргэдийн оролцоотой гоор, ОНХС 10,0 сая	Улаан ам багийн Хэжүүгийн замыг “Мотор сервис” ХХК өргөсгөн засварласан. Улиастай багийн Уурагтын даваа, Хүрдтийн хошуу, Шавартын хэжлэг, Амгалангийн богч, Дунд ар жалгын амны	100

						замыг иргэн Б.Түвшинжаргал, иргэдийн оролцоотойгоор засварласан.	
2.10		Өвтийн Улаан хадны зам засварлана.	Ажлын гүйцэтгэлээр	Иргэдийн аюулгүй зорчих орчин бүрдэнэ	ОНХС 3,0 сая	Хүйтэн булаг багийн Өвтийн Улаан хадны замыг Бат-Өлзий Тохижилт үйлчилгээний компани 2,9 сая төгрөгөөр засварласан.	100
2.11	СЗДҮАХ 1.2.15	Сумын төвийг танилцуулах, сурталчлах өндөрлөгтэй болгох.	Ажлын гүйцэтгэлээр	Танилцуулах өндөрлөгтэй болсон байна.	ОНХСан 44,0 сая Иргэдийн оролцоотой гоор 11,0 сая	2023 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Сумын төвийг танилцуулах, сурталчлах өндөрлөгтэй болох ажилд 55,0 сая төгрөгийн төсөв батлагдсан. Тус ажлын тендерийг 2 удаа зарласан боловч ААН ороогүй.	50
2.12	СЗДҮАХ 1.2.16	Хүүхдийн “Хөдөлмөр амралтын зуслан”-г ажиллуулах.	1	Сурагчдын чөлөөт цагаа зөв боловсон амрах нөхцөл бүрдэнэ	иргэдийн оролцоотой гоор	Улаан амны бага сургуулийг түшиглэн хүүхдийн зуслан байгуулахаар төлөвлөж байна.	50
2.13	АЗДҮАХ	Улс, аймгийн хамгаалалтад байдаг болон Дэлхийн өвд бүртгэлтэй түүх соёлын дурсгалтуудыг дэс дараалалтайгаар хашаажуулж, хамгаалалтыг сайжруулна.	Өвөр Агуйтын дөрвөлжин булшийг хайсжуулах	Хамгаалалт сайжирсан байна.	Иргэдийн оролцоотой гоор	2023 онд аймгийн хамгаалалтад байх Өвөр Агуйтын дөрвөлжин булшийг хайслуулахаар ЭМТ-ийн хуучин хайсыг шийдвэрлүүлсэн.	100
2.14	СЗДҮАХ 1.2.8	6 дугаар багийн хэсэгчилсэн төлөвлөгөө хийнэ.	Ажлын гүйцэтгэлээр	Төлөвлөгөө хийгдсэн байна	ОНХС 30,0 сая	2022 онд Улиастай багийн төвийн хэсэгчилсэн төлөвлөгөөг хийлгэхээр 30,0 сая төгрөг байршуулсан боловч 1 дүгээр багийн төвд баригдахаар болсон тул хэсэгчилсэн төлөвлөгөө хийх шаардлагагүй болсон.	100
Гурав. ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ							

3.1	СЗДҮАХ 1.3.1	Сумын төвийн тэжээлийн аюулгүйн нөөцийг орон нутгаас бүрдүүлэх зорилгоор төр, хувийн хэвшлийн түншлэлээр орон нутгийн өмчийн оролцоотойгоор аж ахуйн нэгж байгуулан газар тариалан, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж ажиллуулна.	Трактор 1	Газар тариалан эрхлэгчдэд дэмжлэг үзүүлсэн байна.	ОНХС 82,0 сая	Сумын нөөцөд 50 тн тэжээл, 40 тн багсармал хүчил тэжээл, малчдын түвшинд 2420 тн өвс, 807 тн гар тэжээл, 1615 тн хужир шүү тус тус бэлтгэсэн байна. Зөрүүлэг 4-р багийн өвсний агуулахад малчид иргэд 24 тн өвс бэлтгэн нөөцөлсөн. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 82,0 сая төгрөгөөр 80 морины хүчин чадалтай тракторыг газар тариалангийн зориулалтаар худалдан авч ашиглаж байна.	100
3.2	СЗДҮАХ 1.3.2	Сумын өвс, тэжээлийн нөөцийг бүрдүүлэх газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд “Атаршсан талбай”-г эргэлтэд оруулж 51 га-аас доошгүй газарт ногоон тэжээл тариална.	Ажлын гүйцэтгэлээр	51 га-д тариалалт хийн ашигласан байна	Улсын төсөв	Билүүт, Онгоцот, Баруун сөдтийн атаршсан 200 га талбайг эргэлтэд оруулахаар хэмжилт хийн эзэнжүүлэн олгосон. Үүнээс 53 га талбайд малын тэжээл тарьж өвс, тэжээлийн нөөц бүрдүүлсэн.	100
3.3	СЗДҮАХ 1.3.3	Стандартын шаардлага хангасан “Мал нядалгааны цэг” байгуулах иргэн, аж ахуйн нэгжийг дэмжин газрын асуудлыг шийдвэрлэн хамтран ажиллана.	1	Шинээр байгуулна.	Төсөл хөтөлбөр	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 19/05 дугаар тогтоолоор манай суманд шинээр 180 сая төгрөгийн өртөгтэй мал нядалгааны цэг байгуулах шийдвэр гарч тендер зарлан “Шоо констракшн” ХХК шалгаран Газрын харилцаа барилга хот байгуулалтын газартай гэрээ байгуулсан. Тус компани суманд ирж ажлаа эхлүүлсэн.	100
3.4	СЗДҮАХ 1.3.6	Сумын бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор Улиастайн дэнж, Билүүтийн хөндлөн, Хойд Агуйтын гуяын нуруу, Галт худаг шинээр гаргах.	Ажлын гүйцэтгэлээр	Шинээр 5 худаг гаргана. 6 худаг засварлана.	ОНХС 71,5 сая	Улиастайн дэнж, Галт, Билүүтийн хөндлөн, Гуяын нуруу зэрэг газарт цооног гаргах тендер зарласан хэрэгжих шатандаа явж байна.	70

		Урд Агуйтын ам, Төмөрт, Хужирт, Бүрэгтий багийн худгуудын засвар хийнэ.					
3.5	СЗДҮАХ	Малчид тариаланчдын зөвлөгөөн зохион байгуулж, технологийн сургалт мэдээлэл, багуудад цагаан идээ, хүнсний ногоо, махан бүтээгдэхүүн савлаж, худалдаанд бэлтгэх арга зүй, малын тэжээл даршлах зэрэг өдөрлөг зохион байгуулна.	1	Сумын брэнд бүтээгдэхүүнтэй болсон байна.	ОНТөсөв 4.0 сая	Малчдын бүсийн зөвлөгөөн"-ийг 2023 оны 06 дугаар сарын 22-ны өдөр Хужирт суманд зохион байгуулж 32 малчин оролцсон. Тариаланчдын зөвлөгөөнийг 4 дүгээр сард зохион байгуулж аймгийн ХХААГ-ын агрономч агро технологийн сургалт хийсэн. Малын дарш бэлтгэх дадлага сургалтыг 2023 оны 09 дүгээр сарын 08-ний өдөр суманд зохион байгуулсан энэхүү сургалтад 20 малчин хамрагдсан. Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Хөдөө аж ахуйн их сургууль, Хөгжлийн шийдэл төрийн бус байгууллага хамтран малын дарш бэлтгэх танхимын болон дадлага сургалтыг 2023 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр Хархорин суманд зохион байгуулсан энэхүү сургалтад сумаас 5 малчин хамрагдсан. 2023 оны 11 дүгээр сарын 08-22-ны хооронд 20 иргэнд "Сүү цагаан идээ боловсруулах" сургалтыг ХХҮГ, Футур сургалтын төвтэй хамтран зохион байгуулсан. Сургалтад хамрагдсан иргэд сүү цагаан идээгээр бүтээгдэхүүн хийж үзэсгэлэн гаргасан.	100
3.6		Малчдын малаа саах дадал хэвшлийг идэвхжүүлж, баг тус бүрээс уламжлалт аргаар сүү, цагаан идээ боловсруулан зах зээлд нийлүүлсэн малчин өрхийг шалгаруулах болзолт уралдаан зарлан урамшуулна.	Ажлын гүйцэтгэлээр	2022 оны суурь түвшин	ОНТөсөв 0,5 сая	Зорилтот жилийн хүрээнд малчин өрхүүдийн дунд малчдын малаа саах дадал хэвшилтээ сайжруулах , уламжлалт аргаар сүү, цагаан идээ боловсруулан зах зээлд нийлүүлсэн малчин өрхийг шалгаруулах болзолт уралдааныг 2023 оны 06 дугаар сарын 20-оос 3 сарын хугацаатай зарласан шалгаруулалтад 15 малчин оролцож, шалгуурын дагуу эхний 3 байрыг шалгаруулсан.	100

3.7		Малын сайжруулахад зориулагдсан ялган ангилах төхөөрөмж чанар малыг тоног	Чанарын шаардлага хангасан байх.	Тоног төхөөрөмж болсон байна.	ОНХС 5,0	Малыг ялган ангилахад шаардлагатай багаж, тоног төхөөрөмжийг шууд худалдан авахаар 3 ХХК-нд үнийн санал хүргэж. “Эко надмид” ХХК -нь 4950,000 төгрөгөөр санал ирүүлж, ажлын хэсэг хуралдаж “ Эко надмид ХХК-аас худалдаж авахаар шийдвэрлэж Бод малын кг хэмжих пүү-1ш бог малын кг хэмжих пүү-1ш Палк метр-1ш Циркүүл метр-1 ш Лент метр-2 ш нийт 4950,000 төгрөгөөр худалдаж авсан.	100
Дөрөв: БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ЧИГЛЭЛЭЭР:							
4.1	СЗДҮАХ 1.4.1	Ойжуулалт, мод үржүүлгийн мэргэжлийн байгууллагыг дэмжиж, сумын төвийн засмал зам дагуу ногоон байгууламжтай болгох.		Ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн байна.	ОНТөсөв, Байгаль хамгаалах сан төсөл, хөтөлбөр, нөхөрлөл, иргэн ААНБ	Төв суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор бүх нийтээр “Мод тарих үндэсний” өдрийг угтаж мод бут, сөөг тарьж ургуулах, ногоон байгууламжид тарьсан мод буцыг услах арчлах, хамгаалах, танаж хэлбэржүүлэх ажлыг зохион байгуулж, мод тарих аргачлал зөвлөмжийг 824 иргэнд тарааж, facebook группээр сурталчилсан. 2023 онд мод тарих арга хэмжээнд нийт 4 аж ахуйн нэгж, 222 иргэн оролцож 12 төрлийн 6557 ширхэг мод, бут сөөг тарьж, амьдралт 80%-тай ургасан. Ойг нөхөн сэргээх, ойжуулах ажлын хүрээнд сумын хэмжээнд давхардсан тоогоор ойн 15-н нөхөрлөл, 8-н ААНэгж нийт 63 га талбайд 116600 ширхэг бортоготой болон шинэсний тарьцаар ойжуулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Ойжуулалтын ажилд нийт 540 гаруй хүн оролцсон. Ойжуулалтын зардалд аж ахуйн нэгж, ойн нөхөрлөл улсын болон өөрийн хөрөнгө нийт 294.0 сая төгрөг зарцуулсан. “Тэрбум мод тарих” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2030 он хүртэл 1 сая мод тарилт хийхээс нийт 214012 ширхэг мод таригдсан.	100

						Сум дундын Ойн ангид 5 га, 1 аж ахуйн нэгжид 3 га, 3 иргэнд 1 га- мод үржүүлгийн газрын асуудлыг шийдвэрлэн тарьц суулгац бэлтгэх ажлууд, үйл ажиллагаа нь жигдэрсэн Сумын төвийн зам дагуух нийт 6 төрлийн 27355 ширхэг мод, бут сөөг тарьсан. Ургалт 85 хувьтай	
4.2	СЗДҮАХ 1.4.2	Усны нөөц нэмэгдүүлэх, булаг, шандын эх хамгаалах, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэх төслийг дэмжинэ	2	Булгийн эхийг хамгаалсан байна.	ОНТөсөв 1,0 сая	Усны нөөц нэмэгдүүлэх, булаг шандны эх хамгаалах, нөхөн сэргээх ажлыг 12 булагийн эх хашиж хамгаалсан.	100
4.3	СЗДҮАХ 1.4.6	Үүртийн тохой-Төвхөн хийд, Улаанцутгалан-Бат-Өлзий гэсэн аялал жуулчлалын маршрутаар хөгжүүлнэ.		Иргэдийн амьжиргааны түвшин дээшилсэн байна.		Улаан цутгалангийн хүрхрээ, Төвхөн хийдийн орчинд 60 гаруй эко гэр, 12 аялал жуулчлалын бааз үйл ажиллагаа явуулж байна. Аймгийн БОАЖГазар, ОХБЦГХЗахиргаа, сумын ЗДТГазар хамтран аялал жуулчлалын бүс нутаг дэвсгэрийн талбайн хог хаягдлыг цэвэрлүүлж, аялал жуулчлал эрхлэгч 26 иргэнийг аймгийн политехникийн коллежид мэргэжлийн сургалтыг зохион байгуулан 22 иргэн амжилттай төгссөн мэргэжлийн үнэмлэхтэй болсон. Орон нутаг, олон улсын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдын хэрэгцээ шаардлага, үйлчилгээний салбарын чанар стандартыг дээшлүүлэх боломж, нийгмийн болон ногоон бизнес, нүхэн жорлон, хог хаягдал зэрэг арга хэмжээний талаарх танилцуулга мэдээллийг хүргэлж, Улаан цутгалангийн эко гэрүүд нийтийн нүхэн нойлоо буулган 20 тн төмөр сав суулган нойлоо шинэчилсэн. Явах замын тэмдэглэгээний тэмдэг 16, хориглох үйл ажиллагааны тэмдэг 10 тодорхой цэгүүдэд тавигдсан.	100

4.4	СЗДУАХ 1.4.7	Найман нуур, Улаан голын Хүрхрээгийн мөсөнд авиралт, Өндөр хясааны сарлагийн фестиваль гэсэн тусгай сонирхлын аяллын маршрутыг хөгжүүлнэ	1	Иргэдийн амьжиргааны түвшин дээшилсэн байна.		Байгаль, түүх, соёл, мал аж ахуй, танин мэдэхүйн чиглэлээр орон нутгийн аялал жуулчлалын маршрутыг бий болгож, түүнд түшиглэсэн соёлын үйлдвэрлэл болон брэнд бүтээгдэхүүнтэй болгох чиглэлээр аялал жуулчлалын хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр морин аялал, хөдөөгийн айлын ахуйтай танилцах аялал, 3 өдөр, 2 шөнийн аялал гэсэн төрлүүд бий болж байна. Найман нуур, Улаан голын Хүрхрээгийн мөсөнд авиралт 11 дэх жилдээ зохион байгуулагдахаар зар, хөтөлбөр цахим мэдээллийн хэрэгсэлд тавигдсан, Өндөр хясааны сарлагийн фестиваль нь 14 дэх жилдээ зохион байгуулагдан аялал жуулчлалын брэнд болсон.	100
4.5		Ойн хөнөөлт шавжаас урьдчилан сэргийлэх устгал тэмцлийн ажил зохион байгуулагдана.	Ажлын гүйцэтгэлээр	Тодорхой хэмжээний газарт ойн хөнөөлт шавжаас урьдчилан сэргийлэх ажил хийгдсэн байна.	ОНТөсөв 300,0 сая	Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын Засаг дарга, ЗДТГ-ын даргатай байгуулсан гэрээний дагуу “Гранд форест” ХХК нь үүргийн шүршигч ашиглан химийн аргаар Бат-Өлзий сумын Билүүтийн ам, Нүхэн чулуу, Шивээт, Давхар, Тархинт, Зүүн сөдтэй, Бүрэгтий, Хойд Агуйтын санж, Билүүтийн амны Аргалант, Хөнөг, Мөст, Мухдаг, Улаан ам, Ар ангилаг, Байц, Хятруун, Бөөрөг, Бөөргийн хавтгай, Өвтийн ам, сумын төвийн арын мод, Могойт, Мойлт, Бугат, Хамрын ам зэрэг газарт нийт 7407 га талбайд гүйцэтгэсэн. Ойн хөнөөлт шавжийн тархалт, голомтын хөнөөлийг хязгаарлах, цаашид бий болох тархалт голомтыг хязгаарлах зорилгоор Бөхөн шөр, Могойт, Бага мойлт, Их мойлт, Бугат, Хөнөгнийн ам, Мөст, Мухтаг, Улаан Ам, Ар ангилаг, Хятруун, Бөөргийн хавтгай, Билүүт, Зүүн сөдтий, Цагаан азарга зэрэг газарт 10000 га талбайд онгоцоор	100

						авиамикробиологийн аргаар хийж гүйцэтгэсэн.	
4.6		ЕБС-ийн 1 ангийг байгаль орчныг хамгаалах дадал хэвшил олгох бүлэг болгон тохижуулж, үйл ажиллагааг тогтмолжуулах.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Сурагчдад байгаль орчноо хамгаалах мэдлэгийг идэвхжүүлнэ	ОНТөсөв 3,0 сая	Сурагчдад байгаль орчныг хамгаалах дадал хэвшил олгох зорилгоор ЕБС-д нэг ангийг эко танхим болгон тохижуулсан. Мөн тус ангийн сурагчдаас эх дэлхийгээ хайрлан хамгаалах, хүн байгалийн харилцан шүтэлцээ, эх дэлхийгээ зөв шүтэх сэдвийн хүрээнд олон үйл ажиллагааг зохион байгуулсан. 8а ангийн сурагчид 3 баг болон хүний хортой үйл ажиллагаа, ан амьтнаа хайрлан хамгаалах, ховордсон ан амьтад, усны ач холбогдол усны хомсдол зэрэг сэдвүүдээр мэдээлэл цуглуулан, байгаль дэлхийгээ зөв шүтэх, хог хаяхгүй байх талаар зөвлөгөө, уриалга бэлдэж 1-9 дүгээр ангийн 45 бүлгийн 1125 сурагчдад нөлөөллийн ажлыг зохион байгуулсан. 10-12 дугаар ангийн сурагчдын дунд видео бичлэгийн уралдааныг зохион байгуулж дүгнэн, уралдаанд ирсэн бүтээлүүдийг олон нийтэд сурталчлан эх дэлхийгээ хайрлан хамгаалахыг олон нийтэд уриалсан. Мөн 8 дугаар үеийн сурагчид танхимын бус сургалтын хүрээнд арын мод, рамын дэнж хэсгийн хог хаягдлыг цэвэрлэн хог хаягдлаа хаяхгүй байхыг хүмүүст уриалсан. Өвөрхангай аймгийн 19 сумын сургуулиудад үйл ажиллагаа явуулж буй эко клубүүд, байгальд ээлтэй анги хамт олны дунд зохион байгуулагдсан " ЭКО КЛУБУУДИЙН ЧУУЛГА УУЛЗАЛТ"- д манай сургуулийн эко клубийн сурагчид, 8а ангийн сурагчид маань оролцож тухайн хичээлийн жилд хийсэн үйл ажиллагаагаараа аймагтаа ТУСГАЙ байрт шалгарсан амжилт үзүүлсэн.	100

4.7		Ойн хөнөөлт шавжаас урьдчилан сэргийлэх, устгал хийх үүргийн шүршигч багажтай болно.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Шүршигч багажтай болсон байна.	ОНХС 7,5 сая	Үүргийн утаа тавигч багажийг 2023 оны 2 дугаар сарын 17-ны өдөр "Царс мод" ХХК-аас бширхэг үүргийн шүршигч багаж 1 бүрийн үнэ-1,250.000 Бат-Өлзий сумын ЗДТГазар гэрээ байгуулан худалдан авалт хийсэн. Утаа тавих марк 6НҮВ-25В(W) , Хор хийх савны багтаамж 6литр, бензиний савны багтаамж 1,6 литр, ашиглалтын хурд, Хүчин 25L/h чадалтай багаж авсан.	100
4.8		Мод үржүүлгийн газарт шилмүүст болон навчит модны үр, мөчир, бордоо худалдан авна.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Тарьц, суулгацын нөөцтэй болно.	ОНТөсөв 15,0 сая	Сум дундын ойн анги нь Орон нутгийн төсвийн хөрөнгөөр Шилмүүст болон навчит модны үр, мөчир, бордоо худалдан авч ЗДТГ-тай 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр гэрээ байгуулсан. Үүнд: Марганц-20кг Гумин-25кг Бортого-5500ширхэг Гоёл чимэглэлийн модны үр-10кг Улиас, бургас мөчир-12500 ширхэг Хар шороо, элс, бууц, хайрга- 18тн тус тус худалдан авч стандартын шаардлага хангасан сайн чанарын үр, мөчир, бордоо, зэргийн гэрээний дагуу 2023 оны 04 дүгээр сарын 15-ны дотор хийж гүйцэтгэсэн.	100
4.9		Мод үржүүлгийн газарт худаг (цооног) гаргана.	1	Худаг гаргасан байна.	ОНТөсөв 15,0 сая	Мод үржүүлгийн газарт тарьц суулгацын усан хангамжийг нэмэгдүүлэх зориулалтаар 15.000.000 сая төрөгийн төсөвт өртөгтэй гүний худгийн цооног ухуулах ажил гүйцэтгэсэн. Гэрээний дагуу ажлыг "Баян говь ус" ХХК 2023 оны 04 сарын 20-оос 2023 оны 05 сарын 27-ны хооронд чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэсэн. Үүнд: Худагт Qi 1,5 квт 6 тн цахилгаан насос маркийн ус өргөгч-50 PVC хоолой 20 м маркийн хөдөлгүүр тавив. Худгийн цооног- 30м Насосыг- 20м гүнд байрлуулав.	100

						Урт нь-20м Бэхэлгээний тороос- 30м	
1.2. Тав: ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ							
5.1	СЗДҮАХ 1.5.1	Гэр бүлийн тогтвортой байдлыг хангах зорилгоор мэргэжлийн байгууллагын хийсэн судалгаа, нотолгоонд тулгуурлан гэр бүлийн боловсрол олгох ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.	2 удаа	Багийн засаг дарга нар, байгуул лагуудын нийгмийн ажилтнууд тай хамтран судалгааг нарийвчлан гаргаж, мэргэжлийн сургалтын байгууллага, лектор багш нартай хамтран сургалт нөлөөллийн ажлууд хийгдсэн байна.	ОНТөсөв	Хамтарсан багийн судалгаанд тулгуурлан гэр бүл төлөвлөлт, тогтвортой гэр бүл, гэр бүлийн эерэг харилцаа, архидалтын хор уршиг, хүүхдээ хэрхэн хүмүүжүүлэх, хүүхдэдээ тавих хараа хяналтыг сайжруулах зорилгоор “Гэр бүлийн үнэ цэн” уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулан видео бэлтгэн олон нийтийн сүлжээгээр цацаж 5879 хүнд хүрсэн. 2023 оны хагас жилийн байдлаар гэр бүлийн боловсрол олгох чиглэлээр 3 удаагийн сургалт, 2 нөлөөллийн ажлыг зохион байгуулж 418 иргэн хамрагдсан.	100
5.2	СЗДҮАХ 1.5.2	Залуу гэр бүлд чиглэсэн зөвлөгөө өгөх үйлчилгээг нэвтрүүлж, гэрлэлтийн үнэ цэнэ, гэр бүлийн үүрэг хариуцлагын талаарх ойлголтыг нэмэгдүүлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллана.	80%	Хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй хүүхэд, гэр бүлд үйлчлээ үзүүлэх хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвтэй болж иргэний нийгмийн байгууллагатай хамтран		Хүүхэд хамгааллын 108 утсанд 2023 онд гэр бүлийн хүчирхийллийн 8 дуудлага ирж хамгааллын хариу үйлчилгээ үзүүлж хаасан 4 кейс байна. Түр хамгаалах байранд 10, 11 дүгээр сард 4 хүн үйлчлүүлснээс насанд хүрээгүй 2 охиныг өөрийн биеэр нийт 28 цаг аюулгүй байдлыг ханган ажиллаж, харилцан ярилцаж, сэтгэл зүйн зөвлөгөө өгч эцэг, эх болон хуулийн байгууллагад хүлээлгэж өгсөн. Сумын хэмжээнд энэ онд гэр бүл салалтын судалгааг гаргахад 3 гэр бүл салсан байна. Шалтгаан нөхцөл нь 1. Зан	100

				иргэдэд, зөвлөгөө өгч, сургалт нөлөөллийн үйл ажиллагаа явуулах орчин бий болсон байна.		араншин 2. Архидалт 3. Хадам аав, ээжээс шалтгаалсан салалт гарч байна. “Бага насны хүүхдийг ахуйн ослоос урьдчилан сэргийлэх”, “Гэрийн дүрэм”, “Хүүхдэдээ хайраа харуулах бодит арга замууд”, “Хүүхэд бол маш том ертөнц”, “Хүүхдийн хөгжил”, “Амь нэгтэй хөршүүд”, “Хүүхэд гэр бүлдээ жаргалтай”, Хүүхдийг эергээр хүмүүжүүлэх 8 арга, “Хүүхдийн эрхийн тухай хуулиуд”, “Унаж бэртэхээс сэргийлье”, “Үе тэнгийн дээрэлхэлтийн эсрэг хамтдаа”, “Хүүхдээ дэлгэцийн хамаарлаас сэргийлье” зөвлөмжийг эцэг эхчүүд, иргэдэд цахимаар тогтмол хүргэж байна.	
5.3	СЗДҮАХ 1.5.3	Гэр бүлд ээлтэй орчин бүрдүүлэх, эцэг эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргыг түгээн дэлгэрүүлэх сургалт, арга хэмжээг зохион байгуулна.	85%	Сургагч багш нараар дамжуулан хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга сургалтад эцэг эхчүүдийг үе шаттай хамруулан, хандлагыг өөрчилсөн байна.		Хүүхдийн эсрэг хүчирхийллийн “Үжин” төвийн тэргүүн Ундраа 2023 оны 04 дүгээр сарын 20-ний өдөр суманд ирж хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн сургалтыг зохион байгуулж 258 эцэг, эх, иргэн хамрагдан гэр бүлийн үнэ цэн, гэр бүлийн хүчирхийллийн хор уршиг, гэр бүлийн харилцаа, эрүүл зөв амьдралын дадалд суралцах, хүүхдийн хөгжил, хамгаалал, хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргын талаар иргэд мэдээлэлтэй болсон. Мөн олон улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан гэр бүл төлөвлөлт, гэр бүлийн харилцаа, тогтвортой гэр бүл, хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга, угийн бичиг хөтлөхийн ач тус сургалтыг 2 удаа зохион байгуулан 129 иргэн хамрагдсан. 2023 оны 11 дүгээр сарын 8 нд I, II дугаар цэцэрлэгийн багш ажилтанд хүүхэд хамгааллын сургалт орж 40 хүн хамрагдсан. “Хүүхэд ба хариуцлагатай аав, ээж” сургалтад “хүүхэд хүмүүжлийн эерэг арга”, “харилцаа хандлага”, “хүүхэд хамгаалал, эцэг эхчүүд хүүхэдтэй тавих хараа хяналтаа сайжруулах”, жендерийн	100

						эрх тэгш байдлын тухай сургалтад нийт 302 хүн хамруулсан.	
5.4	СЗДҮАХ 1.5.4	Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран хөдөөгийн залуучуудыг хөгжүүлэх, эрүүл амьдралын хэв маягт суралцах явуулын үйлчилгээг нэвтрүүлж, залуучуудын оролцоог нэмэгдүүлнэ.	Ажлын гүйцэтгэлээр	Хөдөөгийн 15-34 насны залуучуудад хүрч ажилласан байна.		БЗДХ-аас урьдчилан сэргийлэх, гэр бүлийн хүчирхийлэл, Архи согтууруулах ундаа, утаат болон электрон тамхины хор уршгийн талаар “эерэг хандлага ба хорт зуршил” сургалтыг 3 удаа зохион байгуулж нийт өсвөр насны 288 залуу хамрагдсан. Бат-Өлзий сумын Социал Демократ Монголын Залуучуудын Холбоотой хамтран зохион байгуулсан “SDY CUP” спортын бага наадамд зургаан багийн 300 орчим залуучууд оролцоноос 200 орчим нь хөдөөгийн залуус байсан. Мөн 1-6 дугаар багийн иргэдийн дунд “Миний нутаг сайхан” урлагийн бага наадмыг зохион байгуулсан. Оролцогчдын 80% нь 18-30 насны залуус байсан.	100
2.1. ЗУРГАА: НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО ЗОРИЛТУУД							
6.1	СЗДҮАХ 2.1.1	Сумын иргэдийг урьдчилан сэргийлэх болон эрт илрүүлгийн үзлэгт хамрагдах хамрагдалтын хувийг 30%-д хүргэнэ	30%	Хүн амын өвчлөлийг эрт оношлоно.		Эрт илрүүлэгийн үзлэгийг зорилтот насны ангиллаар анхан шатанд 0-17 насны 2852 хүүхэд хамрагдахаас 1515 хүүхэд хамрагдсан. Үүнээс шүдний өвчлөл 32%-г эзэлж байна. Нийт хамрагдсан хүүхдийн 0,8% буюу 23 хүүхэд харааны өөрчлөлтэй, 1 хүүхэд цусны сахартай гэж оношлогдоод дээд шатлалд хүргэгдэн эмчлүүлж байна. 10 хүүхэд гүйлсэн булчирхайн архаг үрэвсэлтэй, цус багадалттай 5 хүүхэд жингийн алдагдалтай 6 хүүхэд байна. Гүйлсэн булчирхайн архаг үрэвсэлтэй гэж оношлогдсон 10 хүүхдээс 5 хүүхдийг эмнэлэгт эмчлэн эрүүлжүүлсэн. 2 хүүхдийг дээд шатлалд илгээсэн. Хөдөөгийн алслагдсан багаар явуулын амбулатори ажиллаж 300 гаруй хүүхдэд үзлэг хийж 0,9 сар-8 настай хүүхдүүдийг улаан бурхны нэмэлт дархлаажуулалтад хамруулсан. Нийт 1434 хүүхэд	100

					<p>хамрагдахаас 788 буюу 58,8% нь хамрагдсан.</p> <p>Цэцэрлэгийн насны 100 гаруй хүүхдэд амны хөндийн үзлэг хийж 72 хүүхэд шүдний цоорол өвчлөлтэй байснаас 21 нь шүдээ эмчлүүлсэн.</p> <p>0-5 насны хүүхдүүдийг гэрийн эргэлтээр үзэж 220 хүүхдэд өндөр тунт А амин дэм 100 гаруй хүүхдэд Д амин дэм уулгасан. Онцгой хяналтанд байдаг суурь эмгэгтэй 27 хүүхдийг хяналтын үзлэгт Өвөрхангай аймгийн БОЭТ рүү илгээсэн. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг нийгэмшүүлэх өдөрлөгт 8 хүүхдийг хамруулж тус хүүхдүүдэд А, Д амин дэм уулгав.</p> <p>Урьдчилан сэргийлэх үзлэгт АГ- 527 иргэн ЧШ-561 иргэн ,Хөхний үзлэгт -656 иргэн, УХХ-82 иргэн тус тус хамрагдсан.</p> <p>“Эрүүл монгол хүн” аяны хүрээнд УБ хотоос нарийн мэргэжлийн эмч нарын баг сумын төв болон Улаан-Ам багт 10 чиглэлээр урьдчилан сэргийлэх үзлэг оншилгоо хийсэн. Сумын төвд давхацсан тоогоор 318 иргэн хамрагдсан. . Үүнээс Дотор-86, хүүхэд-16, Зүрхний цахилгаан бичлэг-24, Мэдрэл-36, сэтгэц-10, Рентген-46, Нүд-42, ЧХХ-32, Шүд-26 иргэн. Үзлэгийн үр дүнд элэгний хавдар шинээр илэрч, зүрх судасны дутагдалтай 2 иргэний нэгийг дээд шатлалын байгууллагад илгээж, нэг иргэнийг сумын эмнэлэгт хэвтүүлэн эмчиллээ.</p> <p>Улаан ам багт нийт давхацсан тоогоор 238 иргэн үзлэгт хамрагдсан. Үүнээс дотор 47, Хүүхэд 23, мэдрэл 21, сэтгэц 7, гэмтэл 18, шүд 39\ ломбо болон түрхлэг\, ЧХХ 23, Рентген 34, ЗЦБ 26 байсан.</p> <p>2023 оны 07 сарын 01, 02 нд Өвөрхангай аймгийн БОЭТ-ийн Дотрын ЭХО, Нүд, Шүд, ЧХХ, Мэдрэл, Сэтгэц, Гэмтэл, Нөхөн сэргээх, уламжлалт, настны эмч нар ирж</p>
